



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 12 сарын 05 өдөр

Дугаар А/806

Ховд

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.4-ийн "а", Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6, Засгийн газрын 2018 оны 317 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдсан Ховд аймгийн Дарви, Цэцэг, Зэрэг, Чандмань, Дөргөн сумдад мал угаалгын онгоц барьсан нэмэлт ажлыг хүлээж авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Комиссын дарга: Д.Батцэнгэл - Мал эмнэлгийн газрын дарга

Гишүүд

Б.Жамбалдорж - Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын барилгын асуудал хариуцсан мэргэжилтэн

Д.Нямтулга - "МВС" ХХК-ний захирал

Л.Батгэрэл - Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн

Нарийн бичгийн дарга: Ц.Пүрэвсүрэн - Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн

2. Дарви, Цэцэг, Зэрэг, Чандмань, Дөргөн сумдад мал угаалгын онгоц барьсан нэмэлт ажлыг зураг төсвийн дагуу шалгаж хянан баталгаажуулж шийдвэр гаргахыг Улсын комиссын дарга /Д.Батцэнгэл/-д үүрэг болгосугай

ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ  Т.ЖАРГАЛСАЙХАН



02.03928
D/Zax-A/806-Да